



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

СБА-2022/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:

Б.Ариунзул

Утас: 70512127

Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠑᠗᠘᠘.᠐᠔.᠒5 № 37
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ
СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ А.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,392,386.00</u>	<u>18,770,878.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	23,392,386.00	18,770,878.00
351	Түүхий эд материал	2,036,218.00	1,256,500.00
35130	Эм боох материал	2,036,218.00	1,256,500.00
354	Хангамжийн материал	21,356,168.00	17,514,378.00
35410	Бичиг хэргийн материал	35,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	00.00	378,800.00
35460	Хүнсний материал	1,940,000.00	180,760.00
35470	Бусад хангамжийн материал	19,381,168.00	16,954,818.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>393,892,324.31</u>	<u>376,094,178.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	393,892,324.31	376,094,178.51
392	Биет хөрөнгө	375,996,324.31	358,198,178.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	362,186,761.00	362,186,761.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,001,769.04	-22,502,653.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,909,440.00	30,909,440.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,396,762.57	-27,680,582.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,099,324.00	28,229,324.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,882,627.79	-20,237,460.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,342,500.00	22,557,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,008,000.17	-15,809,833.29
39217	Ном	5,747,458.88	545,683.20
393	Биет бус хөрөнгө	17,896,000.00	17,896,000.00
39301	Програм хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-385,000.00	-385,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,896,000.00	17,896,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>417,284,710.31</u>	<u>394,865,056.51</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>417,284,710.31</u>	<u>394,865,056.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	417,284,710.31	394,865,056.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	213,838,744.15	213,838,744.15
51101	Өмч: - төрийн	213,838,744.15	213,838,744.15
512	Хуримтлагдсан үр дүн	151,543,364.44	129,123,710.64
51210	Өмнөх үеийн үр дүн	151,543,364.44	151,543,364.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-22,419,653.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	51,902,601.72	51,902,601.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>417,284,710.31</u>	<u>394,865,056.51</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	298,786,000.00	296,675,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	296,786,000.00	252,237,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,581,500.00	1,608,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,581,500.00	1,608,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,581,500.00	1,608,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	292,204,500.00	250,628,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	253,048,000.00	250,628,800.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	39,156,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,000,000.00	44,438,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	1,470,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	1,320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	42,968,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	42,968,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	324,998,212.38	313,893,678.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,998,212.38	313,893,678.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,570,570.70	310,802,980.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,173,253.45	197,451,554.73
210101	Үндсэн цалин	147,469,993.78	131,906,385.92
210102	Нэмэгдэл	35,307,425.52	49,196,739.18
210104	Урамшуулал	15,395,834.15	16,348,429.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,889,999.87	25,916,200.00
210201	Тэтгэврийн даатгал	17,478,187.66	18,404,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,906,928.55	1,878,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,484,858.86	1,501,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	365,629.53	375,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,654,395.27	3,756,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,346,569.00	38,301,636.10
210301	Гэрэл, цахилгаан	1,771,305.00	1,216,505.00
210302	Түлш, халаалт	29,821,665.00	34,059,255.10
210303	Цэвэр, бохир ус	3,753,599.00	3,025,876.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,549,476.00	6,601,250.00
210401	Бичиг хэрэг	213,500.00	54,900.00
210402	Тээвэр, шатахуун	414,100.00	325,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,500.00	207,100.00
210404	Ном, хэвлэл	00.00	23,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,646,900.00	1,606,450.00
210408	Бараа материал акталсны зардал	19,807,476.00	4,384,700.00
2105	Нормативт зардал	17,501,748.82	14,280,930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,285,082.00	815,978.00
210502	Хоол, хүнс	16,216,666.82	11,998,852.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,466,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,599,850.00	4,320,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	970,000.00
210604	Урсгал засвар	3,599,850.00	3,350,000.00

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,842,500.00	4,441,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,842,500.00	4,441,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,667,173.56	19,489,470.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	706,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,572,100.00	1,841,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,095,073.56	16,941,370.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,427,641.68	3,090,697.17
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,427,641.68	3,090,697.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,427,641.68	3,090,697.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,212,212.38	-17,217,878.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	893,015.99	5,201,775.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	893,015.99	5,201,775.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-893,015.99	-5,201,775.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,105,228.37	-22,419,653.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,838,744.15	51,902,601.72	151,543,364.44	00.00	417,284,710.31
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,838,744.15	51,902,601.72	151,543,364.44	00.00	417,284,710.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,838,744.15	51,902,601.72	151,543,364.44	00.00	417,284,710.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-22,419,653.80	00.00	-22,419,653.80
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,838,744.15	51,902,601.72	129,123,710.64	00.00	394,865,056.51

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	294,204,500.00	295,067,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	292,204,500.00	250,628,800.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	292,204,500.00	250,628,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	253,048,000.00	250,628,800.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	39,156,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,000,000.00	44,438,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	1,470,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	1,320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	42,968,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	42,968,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	291,059,500.00	291,852,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291,059,500.00	291,852,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,631,858.32	288,761,502.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,173,253.45	197,451,554.73
210101	Үндсэн цалин	147,469,993.78	131,906,385.92
210102	Нэмэгдэл	35,307,425.52	49,196,739.18
210104	Урамшуулал	15,395,834.15	16,348,429.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,889,999.87	25,916,200.00
210201	Тэтгэврийн даатгал	17,478,187.66	18,404,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,906,928.55	1,878,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,484,858.86	1,501,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	365,629.53	375,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,654,395.27	3,756,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,626,569.00	38,301,636.10
210301	Гэрэл, цахилгаан	1,771,305.00	1,216,505.00
210302	Түлш, халаалт	29,821,665.00	34,059,255.10
210303	Цэвэр, бохир ус	4,033,599.00	3,025,876.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,686,600.00	3,132,700.00
210401	Бичиг хэрэг	229,100.00	338,900.00
210402	Тээвэр, шатахуун	414,100.00	125,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	467,500.00	164,200.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	47,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,530,900.00	2,457,500.00
2105	Нормативт зардал	20,826,336.00	11,369,512.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,041,300.00	251,400.00
210502	Хоол, хүнс	17,239,236.00	10,239,612.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	545,800.00	878,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,390,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,040,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,842,500.00	5,957,800.00

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,842,500.00	5,957,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,586,600.00	2,242,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,586,600.00	1,349,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,427,641.68	3,090,697.17
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,427,641.68	3,090,697.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,427,641.68	3,090,697.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,145,000.00	3,215,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,145,000.00	3,215,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,145,000.00	3,215,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,145,000.00	3,215,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,145,000.00	3,215,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,145,000.00	-3,215,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	293,597,200.00	290,506,502.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	293,597,200.00	290,506,502.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	293,597,200.00	290,506,502.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	197,483,000.00	197,451,554.73
210101	Үндсэн цалин	00.00	00.00	137,439,200.00	131,906,385.92
210102	Нэмэгдэл	00.00	00.00	43,885,600.00	49,196,739.18
210104	Урамшуулал	00.00	00.00	16,158,200.00	16,348,429.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	25,916,200.00	25,916,200.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	18,404,500.00	18,404,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,878,900.00	1,878,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,501,200.00	1,501,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	375,600.00	375,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	3,756,000.00	3,756,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00	39,618,400.00	38,301,636.10
210301	Гэрэл, цахилгаан	00.00	00.00	2,679,400.00	1,216,505.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00	32,364,800.00	34,059,255.10
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00	4,574,200.00	3,025,876.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	1,787,700.00	1,662,700.00
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	338,900.00	338,900.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	250,000.00	125,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	164,200.00	164,200.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00	47,100.00	47,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	987,500.00	987,500.00
2105	Нормативт зардал	00.00	00.00	12,870,000.00	11,369,512.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00	251,400.00	251,400.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00	11,740,100.00	10,239,612.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	878,500.00	878,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	7,605,000.00	7,605,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	4,255,000.00	4,255,000.00
210604	Урсгал засвар	00.00	00.00	3,350,000.00	3,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	5,957,800.00	5,957,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	5,957,800.00	5,957,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	2242100.00	2242100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	893,000.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	1,349,100.00	1,349,100.00

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	293,597,200. 00	290,506,502 .83
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	293,597,200. 00	290,506,502 .83
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	250,628,800. 00	248,854,866 .73
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00	42,968,400.0 0	41,651,636. 10
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	09.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	10.00	10.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд заасны дагуу /бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох, хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох, хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах, хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах/ үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг нь "Эрүүл эрсдэлгүй, ээлтэй орчин бүрдүүлэлт-2021" зорилго дэвшүүлэн ажиллажээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 291.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	23.3	18.7	4.6
Үндсэн хөрөнгө	393.8	376.0	17.8
Нийт хөрөнгө	417.2	394.8	22.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	417.2	394.8	22.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	417.2	394.8	22.4

Бараа материалын дансны үлдэгдэл 18.7 сая төгрөг болж 4.6 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 376.0 сая төгрөг болж 17.8 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 3.2 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, номын фонд 5.2 сая төгрөгөөр буурсан байна.

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг нь санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 296.6 сая төгрөг буюу 0.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хандив тусламжийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд онд өмнөх оны үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 2.9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 313.8 сая төгрөг буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл, АО-оос НД шимтгэлийн зардал, урсгал зардал, томилолтын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 293.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 293.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 293.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 293.5 сая төгрөгийн төсөв баталснаас 290.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 293.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 290.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 290.5 сая төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь цалин, томилолт, тэтгэмжийн зардал 3.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг нь 2021 онд гүйцэтгэлийн төлөвлөөгөөр 8 зорилго, 25 зорилт дэвшүүлэн ажиллаж 95.7 хувьтай хэрэгжсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Санхүүгийн тайланд аудит хийхэд бусад үндсэн хөрөнгө худалдан авахад 3.2 сая төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.2 Зөвлөмж .

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 54 ширхэг 26.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баруун-Урт сумын 6 дугаар цэцэрлэг	2	3.2	-	-	-	-	1	3.2	1	-